

**Ханбогд сумын Гурван талт зөвлөлийн
ХАМТАРСАН МЭДЭЭЛЭЛ**

**Өмнөговь аймаг
Ханбогд сум**

Иргэдийн хөгжлийн төв

2016 оны 1-р сарын 11

Ханбогд сумын Гурван талт зөвлөлийн ээлжит хурал 2016 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр Иргэдийн хөгжлийн төвд боллоо. Уулзалтанд Ханбогд сумын Захиргаа, Малчид, ОТ ХХК-ийн төлөөллүүд болон Эрх зүйн нийцэл хяналт, зөвлөгөө, омбудсмений газрын (ЭЗХЗОГ) чиглүүлэгч нар оролцов. Мөн Австралийн Күүнсландын их сургуулийн докторант судлаач Б.Бямбажав ажиглагчаар оролцлоо.

Уулзалтаар Гурван талт зөвлөл байгуулагдахаас өмнө болон дараа 2013-2015 онуудад хийгдсэн ажлын тайланг хэлэлцэж батлав. Тус тайланг энэхүү хамтарсан мэдээлэлд хавсарган орон нутгийн олон нийтэд хүргэж байна. Мөн өмнөх уулзалтаар хийхээр тохирсон ажлын хэрэгжилтийн явцыг хэлэлцэж, 2016 онд хэрэгжүүлэх гол ажлын жагсаалтыг гаргав. Зөвлөлийн дараагийн хурлыг 2016 оны 2 дугаар сарын 23-25-нд ЭЗХЗОГ-ийн Хамтарсан баримт тогтоох тухай сургалттай нэгтгэн хийхээр товлов.

Ханбогд сумын Гурван талт зөвлөл

Гурван Талт Зөвлөлийн тухай

Ханбогд сумын Сумын удирдлага, Малчдын төлөөлөгчид болон Оюу толгой компанийн хамтарсан Гурван талт зөвлөл (ГТЗ) нь талуудын маргааныг шийдвэрлэх зорилгоор Харилцан ойлголцлын санамж бичигт зурсны дагуу 2015 оны 6 сарын 8-нд албан ёсоор байгуулагдсан болно. ГТЗ-ийн үйл ажиллагааг Эрх зүйн нийцэл хяналт, зөвлөгөө, омбудсмений газраас (ЭЗХЗОГ) чиглүүлж байна. ЭЗХЗОГ бол Дэлхийн банкны группын Олон улсын санхүүгийн корпорацид чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг хараат бус байгууллага болно.

**ХАНБОГД СУМЫН МАЛЧДЫН ТӨЛӨӨЛӨЛ БА “ОЮУ ТОЛГОЙ” КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨЛ ХАМТРАН 2013 ОНЫ 7 САРЫН 1-НЭЭС 2015 ОНЫ 7 САРЫН 1 БУЮУ ГУРВАН
ТАЛТ ЗӨВЛӨЛ БАЙГУУЛАГДАХ ХҮРТЭЛ ХУГАЦААНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2013 -2015 оны үйл ажиллагааны товч тайлан

Эхний гомдлыг 2012 оны 10 дугаар сард төслийн байршлын ойролцоо амьдарч, амьжиргаагаа залгуулдаг орон нутгийн нүүдэлчин малчид “Оюу Толгойн Хяналт” (үндэсний) ТББ, “Говийн газар шороо” (орон нутгийн) ТББ-ын дэмжлэгтэйгээр гомдол гаргасан.

Хоёр дахь гомдлыг 2013 оны 2 дугаар сард нутгийн 7 малчид ОТ Хяналт ТББ мөн орон нутгийн Говийн газар шороо ТББ-ын дэмжлэгтэйгээр Оюу Толгой компанийн Ундайн голын гольдролыг өөрчлөх төслийн нөлөөллийн асуудлаар Эрх Зүйн Хяналт, Нийцэл, Зөвлөгөө, Омбудсмений Газар (ЭЗХНЗОГ)-т гомдол гаргасан билээ.

Ханбогд сумын 4 багийн иргэдийн нийтийн хурлаас сонгогдсон Малчдын Төлөөлөл ОТ компаний төлөөлөлтэй 2013 оны 7 сараас эхлэн гомдлыг шийдвэрлэх асуудлаар хэлэлцээ хийж үр дүнд нь 2015 оны 6-р сарын 8 -ны өдөр байгуулагдсан Ханбогд сумын засаг захиргаа, Малчдын төлөөлөл болон Оюу Толгой ХХК төлөөлөл бүхий Ханбогд сумын Гурван талт зөвлөлийг Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурж байгуулагдах хүртэл дараах ажлын хийж гүйцэтгэснийг тайлагнаж байна.

Малчдын төлөөлөл болон ОТ компаний төлөөлөл харилцан ойлголцож хамтран ажиллахын төлөө чармайн ажиллаж ирсэн бөгөөд маргааныг шийдвэрлэх үйл ажиллагааг ЭЗХНЗОГ чиглүүлэн зүүчилж ажиллаж ирлээ.

Хийгдсэн гол ажлууд

А.Зохион байгуулалтын тухай

- Малчдын төлөөлөл-ОТ компаний төлөөллийн мэдээлэл солилцох уулзалтыг 2013 оны 3 ба 4 сард 2 удаа зохион байгууллаа.
- Эрх Зүйн Хяналт Нийцэл, Зөвлөгөө, Омбудсмений Газарт (ЭЗХНЗОГ)-т гаргасан 2 гомдлын асуудлаар Малчдын төлөөлөл-ОТ компаний төлөөллийн уулзалт хэлэлцээг 2013 оны 7 сараас 2015 оны 6 сарын 8 буюу Гурван Талт Зөвлөл байгуулагдах хүртэлх хугацаанд нийт 16 удаа зохион байгуулж гомдлыг хэрхэн шийдвэрлэх талаар хэлэлцэж ажиллав.

Б. Хөндлөнгийн Шинжээчдийн Баг ажиллуулах тухай

- ОТ компанитай хамтран Ундай Голын голидрол өөрчилснөөс бэлчээр усанд нөлөөлсөн үнэлгээ хийлгэх ажлыг Хөндлөнгийн Шинжээчдийн Баг (ХШБ) сонгон шалгаруулж, Ажлын даалгаварыг боловсруулан Ханбогд суманд ажиллуулж I үе шатны ажлын тайлан зөвлөмж гаргууллаа.
- ХШБ-ийн I үе шатны ажлын зөвлөмжүүдийг одоогийн Гурван Талт Зөвлөл үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

В. Олон Талт Мэргэжлийн Шинжээчдийн Багийн ажлын даалгавар боловсруулах тухай

- Эрх Зүйн Хяналт, Нийцэл, Зөвлөгөө, Омбудсмэний Газарт (ЭЗХНЗОГ) илгээсэн гомдлыг шийдвэрлэх мөн Нутгийн Малчидад Оюу Толгой төслийн үйл ажиллагааны сөрөг нөлөөлөл учируулсанаар тулгамдсан асуудлыг бүрэн дүүрэн шийдвэрлэхэд туслах, энэхүү үнэлгээний тайлан гарсанаас хойших буюу цаашид гарах өөрчлөлтийг хэмжих сүүр мэдээллийг бүрдүүлэхэд чиглэсэн үнэлгээ хийх Олон Талт Мэргэжлийн Шинжээчдийн Баг ажиллуулах Ажлын Даалгаварыг ОТ

компанитай хамтран эцэслэн боловсруулав.

Г. Гомдлын асуудлыг шийдвэрлэх тухай

- Малчдын хүсэлтийн дагуу өнгөрсөн хугацаанд Малчдын Төлөөлөл нийт 8 удаа ОТ-н уурхайн талбайд орж үйл ажиллагаатай танилцаж, энэ талаар малчдад мэдээлэл түгээв.
- ОТ компанийн уурхайн талбай орчимд нутагладаг малчдад усны хомсдол үүссэн үед зөөврийн усаар түр хангах ажлыг зохион байгуулахад баримтлах Ханбогд сумын малчдад ОТ уурхайн талбайгаас түр хугацаагаар ус зөөвөрлөх журмыг батлан хэрэгжүүлж байна.
- “Оюу толгой” компанийн уурхайн үйлдвэрлэлийн хашаалсан талбайн тодорхой хэсэгт түр хугацаагаар мал бэлчээрлүүлэх журмыг баталж хэрэгжүүлж байна.
- Малчдын төлөөллийн шаардлагын дагуу ОТ компани Ундайн голын голидрол өөрчилсөнтэй холбогдуулан 2015 оны 3 сарын 20-нд орон нутгийн иргэдээс албан ёсоор уучлал гуйв.
- Бор Овоогийн Задгайн шинэ байршлыг тогтоохдоо орон нутгийн малчдын саналыг үндэслэв.
- ОТ-н уурхайн сайтын хойд хаалганаас нүүрсний зам хүртэлх түр шороон замыг хусуулж замын тоосны асуудлыг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэв.
- Нөхөн олговрын гэрээтэй 89 өрх тус бүрт тогтвортой амжиргааны төлөвлөгөө боловсруулахаар ОТ компанийн төлөөлөлтэй тохиролцов.
- ОТ компани болон Малчдын Төлөөллийн хэлэлцээний тухай бүр хамтарсан мэдэгдэл гаргаж ОТ-н орон нутгийн товхимолд хэвлүүлэн орон нутгийн иргэдэд тараан танилцуулах ажлыг тогтмолжуулан хэрэгжүүлж байна.
- Гомдлыг шийдвэрлэж, ЭЗХНЗОГ-ийн оролцоо туслалцаа дуусахад орон нутгийн засаг захиргаа, нутгийн иргэд, ОТ компанийн хооронд үүссэн малчид, бэлчээр, устай холбоотой гомдол хүсэлт, санаачилгыг шийдвэрлэх байнгын механизм болох Гурван Талт Зөвлөлийг 2015 оны 6 сарын 8-нд байгуулав.

2013 оны 7 сараас 2015 оны 6 сар хүртэл хугацаанд
орон нутгийн малчдыг төлөөлж ажилласан Малчдын Төлөөлөл

Жавхлант Баг

Л. Батцэнгэл

Ө. Баттогтох

Д. Намсрай

Гавилууд Баг

Ц. Гүнсмаа

Ц. Баттогтох

Номгон Баг

Б. Батбаатар

Б. Баттөмөр

ОТ Компанийн төлөөлөл

ХАНБОГД СУМЫН СУМЫН ЗАСАГ ЗАХИРГАА, МАЛЧИД, “ОЮУ ТОЛГОЙ” КОМПАНИЙН ХАМТАРСАН ГУРВАН ТАЛТ ЗӨВЛӨЛИЙН 2015 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН

2015 оны 6-р сарын 8-ны өдөр байгуулагдсан Ханбогд сумын засаг захиргаа, Малчдын төлөөлөл болон Оюу Толгой ХХК төлөөлөл бүхий Ханбогд сумын Гурван талт зөвлөл нь Харилцан ойлголцлын санамж бичиг болон Зөвлөлийн дүрэмд заасан зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна. Зөвлөлийн анхны хурал 2015 оны 7 сарын 1-нд зохион байгуулагдсан бөгөөд өнгөрсөн 6 сарын хугацаанд Талууд харилцан ойлголцож хамтран ажиллахын төлөө чармайн ажиллаж байна. Зөвлөлийн үйл ажиллагааг Эрх Зүйн Хяналт, Нийцэл, Зөвлөгөө, Омбудсмений Газар (ЭЗХНЗОГ) чиглүүлэн зуучилж ажиллаж ирлээ.

Хийгдсэн гол ажлууд

А.Зохион байгуулалтын асуудлаар

- Гурван талт Зөвлөлийн хурлыг 7, 9, 10, 11, 12-р саруудад 5 удаа зохион байгууллаа. Зөвлөлийн хурлын хооронд Удирдах нэгжийн хурал 6 удаа хийгдэж, Зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой асуудлыг хэлэлцэж шийдвэрлэв.
- Ханбогд сумын Засаг даргын албан тоотын дагуу Нөхөн олговрын ажлын хэсгийн үүргийг хүлээн авч хэрэгжүүлэх болов.

Б. Судалгааны баг сонгон шалгаруулж ажиллуулах тухай

- Олон талт мэргэжлийн шинжээчдийн баг (ОТМШБ)- ийн судалгааг хэрэгжүүлэх багийг сонгон шалгаруулж, судалгааг JSL Consulting, Oxford University, ШУА-ийн Газар зүйн хүрээлэнгийн судлаачдын хамтарсан баг болон Хөндлөнгийн шинжээчдийн баг (ХШБ) хамтран хэрэгжүүлэх болов.
- Хамтран баримт олж тогтоох үйл явцын (Joint fact finding exercise) гомдлыг шийдвэрлэхэд гүйцэтгэх үүрэг, судалгаанаас хүлээгдэж буй үр дүн, нарийвчилсан төлөвлөгөөний талаар хэлэлцэх нэгдсэн сургалт семинарыг 2016 оны 2 сарын 23-25 бүх талуудыг оролцуулан ЭЗХНЗОГ-аас зохион байгуулах болов.

В. ХШБ-ын 1-р үе шатны ажлын тайланд дурдагдсан Зөвлөмжийн хэрэгжилтийн тухай

- Бор овоогийн задгайн шинэ байршлыг тохиролцож, одоогийн байршил дээр тохижуулах ажлын төлөвлөгөөний төслийг хэлэлцэж, ургамалжуулах талбай болон ургамлын төрлийн талаар Талуудын саналыг тусгаж ажиллахаар тохиролцлоо.
- Уст баг модны карьерийн хонхорт цөөрөм байгуулах ажлыг хэрэгжүүлж эхлэв.
- Ханбогд сумын бэлчээрийн хамтын шинжилгээнд 17 нэмэлт цэгүүдийг сонгон, жил бүрийн судалгаанд хамруулан ажиллаж байна.
- Ханбогд сумын МАА-н хөгжлийн хөтөлбөрт санал оруулав.
- Ундайн гол дагуу мод тарих төсөл боловсруулж байна.
- ХШБ-ын 1-р үе шатны тайланд дурдагдсан Ундайн гол дагуу нутагладаг 59 малчин өрхийн ажлын байр хүссэн 114 иргэнд ОТ компанийн ажлын байрны зарыг зарлагдах тухай бүр тусгайлан хүргэж байхаар тохиров.

- Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэх хүсэлт гаргасан өрхүүдэд бизнес эрхлэхэд нь туслах үүднээс бизнесийн зөвлөхүүдтэй уулзалт зохион байгуулж, бизнесийн зөвлөгөө өгүүлэв.
- ХХААЯ, УУЯ болон Өмнөговь аймгийн захиргааны холбогдох албан тушаалтнуудтай уулзаж, ХШБ-ийн 1-р үе шатны ажлын тайлангийн зөвлөмжийг хэрэгжүүлэхэд дэмжлэг хүслээ.
- Ханбогд хот төлөвлөлтийн усны нөөцийг дахин батлуулах асуудлаар Усны нөөцийн зөвлөлд хүсэлт гаргаж, дэмжин ажиллалаа.
- Хамтын оролцоот усны мониторингийн худгийн усны ундрагын хэмжилтийн аргачлалыг нэвтрүүлж, явцыг тайлагнах ажил үргэлжилж байна.

Г. Чадавхи бэхжүүлэх тухай

- ЭЗХНЗОГ –аас зохион байгуулсан Зөрчил маргааныг шийдвэрлэх чадвар дээшлүүлэх сургалтанд Зөвлөлийн гишүүд хамрагдав.

Хийгдэх гол ажлууд

- ОТМШБ-ийн судлаачидтай хамтран ажиллаж, судалгааны ажлыг амжилттай хэрэгжүүлэх
- ХШБ-ийн 1-р үе шатны ажлын тайлангийн 10-р зөвлөмжийн дагуу Ундайн голын эко системийн эдийн засгийн үнэлгээ хийлгэх асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх
- Ханбогд сумын Засаг даргын тамгын газар, ОТ компани, сумын Цаг уурын Ханбогд өртөөтэй байгаль орчны мониторингийн чиглэлээр хамтарч ажиллах
- Ханбогд сумын иргэд, иргэний нийгмийн байгууллагын байгаль орчны мониторинг хийх чадавхийг дээшлүүлж, идэвхийг нэмэгдүүлэх арга хэмжээ зохион байгуулах
- Гүний хоолойн усны асуудлаар малчдын санал хүсэлтийг тодорхой болгож хэлэлцэн шийдвэрлэх
- ХШБ-ийн 1-р үе шатны ажлын тайлангийн 13-р зөвлөмжийн дагуу “Бэлчээрийн нөөц, малчдын амьжиргаанд учруулсан нөлөөллүүдийг бууруулах” чиглэлээр Ундайн гол дагуу нутагладаг малчдад чиглэсэн төсөл боловсруулах

2016 оны 1 сарын 11